



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2023. 10. 12 № ХТТ/2260
танай _____-ны № _____-т

Мэдээлэл хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн нэгдсэн хуралдаанд хийх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаарх Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт ¹⁷ хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

000235024143

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ, ХАМГААЛАХ, ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ХИЙХ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улс 2008 онд НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцод нэгдэж, УИХ-аас 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг баталснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих, нийгмийн хамгааллыг сайжруулах, тэдний онцлог, чадварт нь тохирсон ажлын байраар хангах, үйлчилгээг сайжруулах чиглэлээр холбогдох салбаруудын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр цөөнгүй арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Монгол Улсад нийт 115.1 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаагийн 40 хувь нь төрөлхийн, 60 хувь нь олдмол шалтгаантай байна. 0-18 насны 11.8 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хэрэгжүүлж байгаа томоохон арга хэмжээнүүдээс онцлон танилцуулъя.

Нэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангах, ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулах талаар

Монгол Улсын Засгийн газраас Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн бүтэц тогтолцоог бэхжүүлж байна. Тухайлбал:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны бүтцэд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн хэлтсийг байгуулж, тэдний эрхийг хангах асуудлыг төрийн бодлого, шийдвэрт тусган ажиллаж байна.

2016 онд Засгийн газрын 136 дугаар тогтоолоор хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар дундын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Үндэсний зөвлөлийг байгуулан ажиллуулж байна. Яамд, зарим агентлагийн дэргэд дэд зөвлөл, аймаг, нийслэл, дүүрэгт Засаг даргаар ахлуулсан салбар зөвлөл байгуулагдсанаар тухайн салбар, орон нутгийн бодлого, үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгамдсан асуудлыг тусган хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдын хандлагад эерэг өөрчлөлт гарах чиглэлээр ахиц дэвшил гарч байна. Үндэсний зөвлөл нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, орон тооны бус дэд болон салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэн зөвлөмж, чиглэл өгч ажиллаж байна. Эдгээр зөвлөлүүд нь оны эхэнд тухайн жилд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, жилийн эцэст тайлан гаргах тогтолцоо бий болсон нь маш том ахиц дэвшил юм. Тус зөвлөлүүдэд холбогдох төрийн байгууллагуудаас гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагын төлөөллийг оруулж, бодлого төлөвлөлт, хэрэгжилтэд тэдний оролцоог ханган ажиллаж байна.

Засгийн газрын 2022 оны 350 дугаар тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, зөвлөлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга ахалж байна.

Мөн 0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссыг 21 аймаг, 9 дүүрэгт байгуулан ажиллаж байна.

Хууль болон конвенцыг хэрэгжүүлэхэд салбар дундын уялдааг хангах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрыг 2018 онд Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр байгуулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэнд, нийгмийн сэргээн засалтын цогц үйлчилгээ үзүүлэх Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийг Засгийн газрын 2019 оны 125 дугаар тогтоолоор байгуулсан. Тус төв нь хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, сэргээн засах, хоёрдогч хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, олон нийтийн оролцоонд түшиглэн хөгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нийгмийн харилцаанд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эцэг эхчүүдэд зориулсан сургалт, нөлөөлөл, хөгжлийн арга хэмжээг зохион байгуулахаас гадна өдөрт 250 хүүхдийг хэвтэн эмчлүүлэх, өдрөөр сэргээн засах үйлчилгээнд хамруулж байна. Түүнчлэн хөдөө орон нутаг, алслагдсан дүүргээс ирсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг 14-21 хоног хэвтүүлэн нарийн мэргэжлийн болон орчин үеийн шинжилгээ, оношилгоо, хөдөлгөөн засал, хөдөлмөр засал, хэл засал, усан ба физик эмчилгээ зэрэг сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлж, тохирох туслах хэрэгсэл /протез, ортопед/-ийн үйлдвэрлэл, засвар үйлчилгээг үзүүлж байна. Төв байгуулагдсанаас хойш давхардсан тоогоор нийт 22 мянга орчим, 2023 оны эхний 3 дугаар улирлын байдлаар 6400 гаруй хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн байна.

Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн хүрээнд Дархан-Уул, Дорнод, Дундговь, Ховд, Хөвсгөл аймгуудад Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг 9 дүгээр сард нээж, үйл ажиллагааг нь бүрэн эхлүүллээ. Эдгээр төвүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгчдэд эрүүл мэнд, нийгмийн сэргээн засах цогц тусламж, үйлчилгээг тухайн орон нутагт нь үзүүлж, гэр бүл, асран хамгаалагчдад чиглэсэн олон үйлчилгээг хүргэж, салбар дундын уялдаа холбоог хангаж ажиллах юм.

Засгийн газраас 2016-2020 онд ЖАЙКА байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн "Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх төсөл"-ийн хүрээнд "Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал" сургалтыг үндэсний хэмжээнд зохион байгуулах хөгжлийн бэрхшээлтэй сургагч багш нарыг бэлтгэн, хандлага ойлголт нэмэгдүүлэх сургалтын тогтолцоог бий болголоо. Энэ хүрээнд 2023 оны байдлаар 500 гаруй удаагийн сургалтаар 40 мянга гаруй төрийн болон хувийн хэвшлийн ажилтан албан хаагч, ерөнхий боловсролын болон их дээд сургуулийн оюутан, сурагчдыг хамруулж, сургалтад хамрагдсан байгууллагууд гадна болон дотоод орчноо хүртээмжтэй болгоход анхаарч ажиллаж байна. Сургалтыг зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрөө

заадаг учир үүгээр дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй залуусыг чадавхжуулан, тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлж байна. Түүнчлэн сургалтыг зохион байгуулах, сургагч багш бэлтгэх харилцааг зохицуулах “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалтыг зохион байгуулах, сургагч багшид эрх олгох” журмыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн хууль, эрх зүйн орчинг сайжруулах хүрээнд холбогдох салбаруудын хуулиудын шинэчлэлийг хийлээ. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлан хэрэгжүүлж байна. Тус хуульд хөдөлмөрийн харилцаанд хүнийг хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлахгүй байх, НҮБ-ын Хүний эрхийн хорооноос ирсэн зөвлөмжийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүний ажлын цагийн хорогдуулсан байдлыг устгах, ажил олгогч нь ажлын байрны тохируулгыг бүрдүүлж өгөх, хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллах боломжтой ажлын байрны жагсаалтыг баталж байсан хүний эрхийн зөрчилтэй заалтыг хасах, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг тэргүүн ээлжид худалдан авах, зайнаас ажиллах боломж нөхцөлөөр хангах зэрэг зарчмын чухал өөрчлөлтүүдийг тусгаж өгсөн. Засгийн газрын 2022 оны 253 дугаар тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа хүний үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг гэрээгээр байнга худалдан авах зэргээр тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн ажил олгогчийг төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх тухай журмыг баталсан.
- Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг энэ оны 7 сард УИХ баталлаа. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.5.13.1-т “Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 0-16 насны хүүхдээ асран ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа эх /эцэг/-ийн нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс төлөх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэж заасны дагуу дээрх хуульд байнгын асаргаатай хүүхдээ асарсны улмаас хөдөлмөр эрхлэхгүй байгаа эцэг эсхүл эхийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг төрөөс 100 хувь хариуцах зохицуулалтыг тусгасан.
- Боловсролын багц хуулийн шинэчилсэн найруулгыг энэ оны 7 сард УИХ-аар хэлэлцэн баталсан. Тус хуульд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сурах эрхийг баталгаажуулж, боловсролын зарчим тэгш хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй, нээлттэй байна¹ гэж тодорхойлоод бүх дагалдах хуульд уг зарчмыг баримтлах бөгөөд багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд багшлах арга зүйн ур чадварыг багш мэргэжлээр суралцаж байгаа бүх оюутан багш эзэмших, бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөр агуулгыг ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн онцлогт тохируулна. Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын тухай хуульд Тэгш хамран сургах боловсрол гэсэн бие даасан бүлгийг оруулж, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, сурах бичиг, хэрэглэгдэхүүн, үнэлгээ, багшийн арга зүй, сургалтын орчин, санхүүжилт, эцэг эхийн оролцоо хамтын ажиллагааг бүхэлд нь тусгасан. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд суралцагчийн ялгаатай хэрэгцээ, ур чадварын түвшинд харгалзсан сургалтын хөтөлбөрт тохируулга хийхээр тусгасан. Дээд боловсролын тухай

хуульд сургалтын байгууллага нь боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай суралцагчийг дэмжих хөтөлбөр баталж, шаардагдах орчин нөхцөлийг бүрдүүлэхээр тусгасан. Түүнчлэн боловсролын бүх шатны сургалтын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын суралцах онцлогийг харгалзан сургалтын хөтөлбөртөө тохируулга хийхээр тусгаж багш бүр ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах, тэднийг сургаж хөгжүүлэх арга зүйн ур чадвар эзэмшсэн байхыг онцгойлон авч үзсэн.

- Төрийн албанд 2022 оны байдлаар нийт 4864 хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллаж байгаагаас 1913 буюу 39.3 хувь нь эрэгтэй, 2951 буюу 60.6 хувь нь эмэгтэйчүүд байна. Төрийн албанд ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй нийт албан хаагчийн 245 буюу 0.5 хувь нь удирдах албанд, 2811 буюу 57.7 хувь нь гүйцэтгэх албанд, 1808 буюу 37.1 хувь нь туслах албанд ажилладаг. Үүнээс төрийн улс төрийн албанд 71, төрийн захиргааны албан тушаалд 533, төрийн тусгай албан тушаалд 38, 4222 хүн буюу төрийн албанд ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний 87 хувь нь төрийн үйлчилгээний албан тушаалд ажиллаж байна. Энэ нь төрийн захиргааны албан тушаалд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллах боломж нөхцөл хангалтгүй байгааг илтгэх нэг үзүүлэлт юм. Иймд хөгжлийн бэрхшээлтэй иргэн төрийн захиргааны албан тушаалд ажиллах боломж нөхцөлийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд 2 дахин бууруулсан зохицуулалтыг Төрийн албаны тухай хуульд нэмэлтээр тусгаж УИХ-аар батлууллаа.
- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргаар хөгжлийн бэрхшээлтэй хүн удирдах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль “Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргаар Төрийн албаны тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд тавигдах ажилласан жилийн тусгай шаардлагыг хангасан, эсхүл өндөр мэргэшилтэй хөгжлийн бэрхшээлтэй хүнийг томилж болох” зохицуулалтыг нэмж тусган баталсан.
- “Төрийн албаны шалгалт өгөх болзол, журам”-д хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар зохицуулалт байхгүй байсныг өөрчилж, шалгалт авах байрыг хүртээмжтэй болгох, төрийн албаны нөөцөөс хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нэн тэргүүнд нөхөх зарчмыг баримтлах, хөгжлийн бэрхшээлтэй иргэний шалгалт өгөх нөхцөл боломжийг бүрдүүлсэн.
- Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2020 онд УИХ-д өргөн барьсан. УИХ-ын чуулганаар холбогдох хуулиудын хооронд нь уялдуулах хүрээнд Газрын багц хуультай хамтран хэлэлцэхээр шийдвэрлэсэн. Хуулийн төсөлд “хот байгуулалтын үйл ажиллагаанд нийтийн эрх ашгийг эрхэмлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх болон олон нийтийн оролцоо, оролцогч этгээдийн эрх тэгш байдлыг хангах”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн дэд бүтэц, нийтээр ашиглах барилга байгууламжид саадгүй хүрэх нөхцөлийг бүрдүүлэх, дэд бүтцийн хэрэгцээг хангах нь хот байгуулалтын баримт бичигт тавигдах үндсэн шаардлага болох”, “гадна тохижилтын ажил, барилга байгууламжийн орц, гарцыг хөгжлийн бэрхшээлтэй болон хөдөлгөөний хязгаарлалттай хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хүртээмжтэй орчинг бүрдүүлэн төлөвлөсөн байх”, “хөгжлийн бэрхшээлтэй хүний саадгүй хүрч үйлчлүүлэх нөхцөлийг хангаагүй хот төлөвлөлт, инженерийн болон нийгмийн дэд бүтцийг барьж байгуулах аливаа төсөл, барилгажилтын шийдэл, зураг төсөлд зөвшөөрөл олгохгүй байх”, “хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй орчны талаарх мэдээлэл

тусгах” зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэсэн чухал зохицуулалтуудыг тусгасан.

- “Орон сууцны ашиглалтын тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ төслийг эцэслэн боловсруулж, УИХ-д өргөн барихаар бэлтгэл ажлыг хангаж байна. Хуулийн төсөлд “орон сууцны барилгад хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан, хүртээмжийг сайжруулсан орчныг бүрдүүлэх” талаарх заалтыг тусгасан.
- Монгол дохионы хэлний тухай анхдагч хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон үйл ажиллагааны төлөвлөгөө, шаардагдах төсвийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар баталсан бөгөөд хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж байна.
- Авто замын тухай хуульд “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тээврийн хэрэгслийг авто зам, замын байгууламж ашигласны төлбөрөөс чөлөөлнө.” гэж тусган баталсан.
- Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 оны 05 дугаар сард УИХ-аар батлуулсан. Хууль шинэчлэгдсэнтэй холбоотой дагалдан гарах журмуудыг шинэчилж байгаа бөгөөд Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилал, зэрэглэл тогтоох, түүнийг олгох, бууруулах, хүчингүй болгох журмын төсөл, жуулчны хөтөч-тайлбарлагчид үнэмлэх олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох болон мэргэжлийн ур чадварын зэрэглэл тогтоох журмын төсөл, Тусгай сонирхлын аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулах журмын төслүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлэх асуудлыг тусгахаар боловсруулж байна.
- Конвенц болон хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг 2017-2021 онд хэрэгжүүлсэн. Үндэсний хөтөлбөр нь 8 зорилт, 32 үйл ажиллагааны чиглэл бүхий хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нэн тэргүүнд тулгамдаж байгаа эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоонд бүрэн дүүрэн оролцох, нийтийн тээвэр, зам, орон сууц, олон нийтийн барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, статистик тоон мэдээллийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой ажлуудыг тусгаж хэрэгжилтийг хангасан.

Хоёр. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хангах талаар

2022-2023 оны хичээлийн жилд нийт хөгжлийн бэрхшээлтэй нийт хүүхдийн 64 хувийг буюу 8228 суралцагчийг бүх шатны боловсролын үйлчилгээнд хамруулж байна. Боловсролын түвшнээр авч үзвэл, сургуулийн өмнөх боловсролд 1498, ерөнхий боловсролд 5673, мэргэжлийн боловсролд 643, дээд боловсролд 414 суралцагч суралцаж байна.

Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль шинэчлэгдэн батлагдаж бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг тэгш хамруулан сургах эрх зүйн орчин сайжирлаа.

Боловсролын ерөнхий хуулиар танхимын сургалтад хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн цогц үйлчилгээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжүүлэх, хөгжлийн

бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд нь боловсролын, эрүүл мэндийн болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарууд хамтран ажиллах, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд тэгш хамруулан сургах боловсролын харилцааг зохицуулах бие даасан бүлэг, Дээд боловсролын тухай хуульд тусгай хэрэгцээ шаардлагатай суралцагчийг дэмжих хөтөлбөр баталж, шаардагдах орчин нөхцөл бүрдүүлэх талаар тусгагдсан.

Тэгш хамран сургах боловсролын талаар 2022-2024 онд баримтлах бодлогын чиглэлийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролд

2022-2023 оны хичээлийн жилд цэцэрлэгт хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих тусгай болон туслах нэмэлт хэрэглэгдэхүүнийг худалдаж авахад зориулж улсын төсвөөс 100.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, 80 цэцэрлэгт 25 нэр төрлийн 384 ширхэг тохирох хэрэглэгдэхүүнийг тус тус нийлүүлжээ.

Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй “Тэгш хамран сургах боловсролыг дэмжих төсөл”-ийн хүрээнд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн дэд бүтцийг сайжруулж илүү хүртээмжтэй болгох зорилтот 4 сургууль, 4 цэцэрлэгийн дэд бүтцийг хүртээмжтэй болгон сайжруулахад 2022 онд зураг төсөл, хамгааллын хяналт шинжилгээний зөвлөх үйлчилгээнд 175.5 сая төгрөг, засварын ажилд 968.9 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн. Мөн төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах үйлийг дэмжсэн тохирох хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийг 527.9 сая төгрөгийн санхүүжилтээр хараа, сонсгол, харилцаа, суралцахуй, хөдөлгөөний, зан төлөв, сэтгэл хөдлөлийн бэрхшээлтэй хүүхдийн гэсэн бүрэлдэхүүнтэйгээр нийт 19 төрлийн 212 ширхэг бүтээгдэхүүнийг дээрх сургууль, цэцэрлэгүүдэд нийлүүлсэн. Эдгээр сургууль, цэцэрлэгт Хүүхэд хөгжлийг дэмжих загвар танхимыг байгуулахад 631.7 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэсэн байна.

“Дэлхийн боловсролын түншлэл” олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслөөс 2023 -2024 оны хичээлийн жилд 4 аймаг, 2 дүүргийн нийт 18 сургуулийн Хүүхэд хөгжлийн дэмжих танхимд 1.0 тэрбум орчим төгрөгийн тоног төхөөрөмж, тохирох хэрэглэгдэхүүн нийлүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах орчныг сайжруулж байна.

Танхимын сургалтад тогтмол хамрагдаж чадахгүй байгаа байнгын асаргаатай болон хэвтрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсролын үйлчилгээ үзүүлэх хүүхэд хөгжлийн дэмжих төвийг ерөнхий боловсролын 70 дугаар сургууль, Ээлтэй ертөнц төрийн бус байгууллагын дэргэдэх Энэрэл хүүхэд хөгжлийн төвд туршилтаар зохион байгуулж, боловсролд хамрагдаж чадахгүй байсан нийт 40 хүүхдийг хамруулан 288.0 сая төгрөгийн санхүүжилт олгоод байна.

Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын салбарт

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг тэгш хамруулан сургах жирийн суралцагчидтай хамтран сургах, оюутан солилцооны хөтөлбөрүүдийг 2021-2022, 2022-2023 оны хичээлийн жилд МСҮТ, Политехникийн коллеж дээр хэрэгжүүлж,

дадлагын хичээлийг хөгжлийн бэрхшээлтэй, бэрхшээлгүй суралцагчдыг хамтад нь зохион байгуулдаг боллоо.

Жил бүр хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн олон улсын өдрийг угтан “Боловсролд тэгш хамруулан сургах” сургалтын ач холбогдлыг таниулах, хандлагыг өөрчлөх сургалт мэдээллийг төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж хэвшлээ.

Монголын хараагүйчүүдийн үндэсний төвийн дэргэдэх Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах зорилгоор 250.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын суралцахад шаардагдах асуудлыг суралцагч бүрээр судлан тухайн хичээл бүрд тохирсон “тохиргоо”-г боловсруулан 42 багшид хүргүүлэн ажиллалаа.

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулан цахим үйлчилгээний ажилтан, архив, бичиг хэргийн ажилтан, үйлчилгээний ажилтан мэргэжлээр багш, суралцагчийн гарын авлагыг чадамжийн нэгж бүрээр боловсруулж Европын холбооны санхүүжилттэйгээр хэвлэн түгээлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дагнан сургадаг Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад ТИКА төслийн 100.0 сая төгрөгийн санхүүжилттэйгээр тогооч, талх нарийн боов үйлдвэрлэлийн ажилтан мэргэжлийн дадлагын газрын тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг шинэчилсэн. Мөн Дэлхийн зөн ОУБ, Lend MN, Макс шил цонхны үйлдвэр, Зориг сантай хамтран “Зоригтой бай” төслийн хүрээнд “Нөхөн сэргээх, сэтгэл заслын өрөө”-г бүрэн тохижуулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид тохирсон ширээ сандал бэлтгэж, зориулалтын шат, ханын бариул, ариун цэврийн өрөөг тохижуулж сургалтын төлбөрийг 70-100% хөнгөлөх арга хэмжээг авч хэрэгжүүллээ. “Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч болон мэргэжлийн багшид зориулсан суралцагчийн гарын авлага 5”-ыг Европын холбооны төслийн хүрээнд боловсруулж ашиглаж байна.²

Дээд боловсролд

Засгийн газрын 2022 оны 346 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын дагуу суралцагчдад төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг 2023 оны эхний хагас жилд дараах байдлаар олгосон байна. Үүнд:

- Бакалавр, магистр, докторын хөтөлбөрт хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй 473 суралцагчид 843.1 сая төгрөг;
- Бакалаврын хөтөлбөрт суралцаж байгаа, эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй 282 суралцагчид 544.4 сая төгрөг;
- Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн бакалаврын хөтөлбөрт суралцаж байгаа 1382 суралцагчид 2.6 тэрбум төгрөг;
- Төрийн өмчийн их, дээд сургуульд хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч мэргэжлээр суралцаж байгаа 73 суралцагчид 99.9 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг тус тус олгоод байна.

² БШУЯ, Мэргэжлийн боловсролын хэлтсийн мэдээлэл

Их дээд сургуульд элсэх элсэлтийн шалгалтын талаар

Сүүлийн үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн элсэлтийн ерөнхий шалгалт өгөх тоо нэмэгдэж байна. Энэ хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй шалгуулагч элсэлтийн ерөнхий шалгалтад бүртгэгдсэн тохиолдолд шалгалтын үед шаардлагатай тохируулгын талаар урьдчилан өргөдөл бичүүлэн авч, элсэлтийн ерөнхий шалгалт өгөхөд зориулсан тусгай өрөө бэлтгэх, шалгалтын цагийг уртасгах, шалгалтын даалгаврыг брайлаар, том форматаар хэвлэх, дохионы хэлмэрч, туслах багш ажиллуулах зэрэг дэмжлэг үзүүлж байна. 2020 онд 13 шалгуулагч бүртгүүлж 12, 2021 онд 22 шалгуулагч бүртгүүлж 20, 2022 онд 31 шалгуулагч бүртгүүлж 31, 2023 онд 33 шалгуулагч бүртгүүлж 29 хөгжлийн бэрхшээлтэй шалгуулагч элсэлтийн ерөнхий шалгалтад хамрагдсан байна. 2020-2023 онд элсэлтийн ерөнхийн шалгалтад нийт 99 хөгжлийн бэрхшээлтэй хүн бүртгүүлж, 92 нь шалгалтаа өгсөн байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд боловсролын салбарт сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургууль, их дээд сургууль, коллеж, шинжлэх ухааны байгууллагын нийт 102,8 мянган ажиллагсдын 2.1 хувь буюу 2261 нь хөгжлийн бэрхшээлтэй ажилтан байна.

Гурав. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний талаар

Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд 2020 оны 05 дугаар сард эмнэлгийн урт хугацааны тусламж, үйлчилгээг шинээр тусгасан. Урт хугацааны тусламж, үйлчилгээний эрх зүйн орчин боловсронгуй болсноор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдал бүрэн хангагдах юм.

Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан “Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусламж үйлчилгээний журам”-д үйлчлэх хүрээний хөгжлийн бэрхшээлтэй жирэмсэн эмэгтэйчүүд, хөдөлмөрийн чадвар түр алдалттай нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн судалгааг гаргаж, гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ гэсэн заалтуудыг онцлон тусгаж оруулсан.

Эрүүл мэндийн салбарт эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээний соёлтой холбоотой стандартыг хэрэгжүүлэхээр “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS7014:2023 стандарт”-ыг анх удаа батлуулсан. Уг стандартад хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчтэй хэрхэн харилцах, эрүүл мэндийн байгууллагын гадна болон дотоод орчинд тавигдах шаардлагад хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй орчин бүрдүүлэх, хэвтэн эмчлүүлэх тасагт хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй өрөөг нэгээс доошгүй, зориулалтын тоноглол бүхий ариун цэврийн өрөөг төлөвлөх зэрэг 20 орчим тусгайлсан заалтыг тусгасан.

Түүнчлэн “Нярайн шарлалтын үеийн оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн зааврын боловсруулж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд нярайн дутуу төрөлтийг бууруулах, дутуу нярайд үзүүлэх эмнэлгийн тусламжийг сайжруулах, нярайн амь насыг аврах, амьсгалын дистресс хам шинжийн эмчилгээнд хэрэглэх сурфактант эмчилгээг шинээр нэвтрүүлсэн.

ЭМДҮЗ-ийн 2020 оны 13 дугаар тогтоолоор олон улсын нэршил бүхий 11 ерөнхий нэршлийн 41 худалдааны нэршлийн эмэнд 70 хувиар үнийн хөнгөлөлт үзүүлж байсан бол уг тогтоолоор нийт олон улсын нэршлээр 25, худалдааны нэршлээр 78 нэр төрлийн эмийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх боломжийг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлсэн. ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолоор тархины саа, саажилт, уналт таталт оноштой байнгын диспансерийн хяналтад байдаг 19 хүртэлх насны хүүхдийн байнга хэрэглэдэг эмийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувийн хөнгөлөлттэйгөөр олгох асуудлыг шийдвэрлэсэн.

Эрүүл мэндийн сайдын тушаалаар “Төрөөс эмийн зардлыг нь хариуцан амбулаториор эмчлэх өвчний жагсаалт, эм олгох үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг баталсан. Тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд ЭМДЕГ-ын цахим мэдээллийн системд уналт таталттай 5000 гаруй хүүхдийн мэдээллийг оруулж уналт, таталтын эсрэг эмийг 2022 оны 09 дүгээр сараас Ази Фармын салбараар олгож эхэлсэн. Цаашид уналт таталтын эмийг Новартис байгууллагатай хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсад оруулж ирэхээр ажиллаж байна.

Эрүүл мэндийн анхан шатлалын байгууллагад хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг оношлох, үнэлэх, эрсдэлтэй хүүхдийг лавлагаа шатлалд шилжүүлэх тогтолцоог сайжруулах зорилгоор “Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-т Монгол хүүхдийн хөгжлийг үнэлэх түргэвчилсэн үнэлгээ (МОРБАС)-ний асуумж, сорилыг тусган шинэчлэн боловсруулж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулав.

Амаржих газруудын тусламж, үйлчилгээний чадавх, хүртээмжийг сайжруулах зорилгоор 2021-2022 онд 80 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээр бүх амаржих газрын төрөх орыг иж бүрэн шинэчилж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд саадгүй төрөх боломжтой болсон. 2022 онд хөгжлийн бэрхшээлтэй 41 үйлчлүүлэгч, 2023 оны эхний хагас жилийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 11 үйлчлүүлэгч эсэн мэнд амаржсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан мэдрэл, дотор, чих хамар хоолой нүд, шүд, сэтгэцийн эмч, хэл засал, сэргээн засалч эмч, удам зүйч, мэдрэлийн мэс заслын эмч нарын хамтарсан үзлэгийг жилд 1 удаа зохион байгуулах төлөвлөгөө гарган, 2022 оны үзлэгийг 08 дугаар сараас 500 гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дээрх төрөлжсөн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулсан.

Мэдрэлийн ёзоор тайрах мэс заслыг Монгол Улсад нутагшуулах төрөлжсөн мэргэшлийн эмч нараас бүрдсэн “Үндэсний баг”-ийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар байгуулж, мэс засал хийлгэх шаардлагатай нийт 250 хүүхдийн нэрсийн жагсаалтыг гаргасан. Энэ хүрээнд БНТУ-ын Лив эмнэлгийн тархины саатай хүүхдэд ризотоми мэс засал хийдэг 2 зочин профессор Улсын гуравдугаар эмнэлэгт 3 дугаар сард ажиллаж, 2022 оны 9 сард мэс засал хийсэн 5 хүүхдийн үр дүнг хянахаас гадна ЭХЭМҮТ-ээс эрэмбэлсэн 50 орчим хүүхдэд үзлэг хийн, 9 хүүхдэд мэдрэлийн ёзоор тайрах хагалгаанд орох заалт, оношийг тогтоолоо. Мөн зүрхний хүнд хэлбэрийн гажигтай 28 хүүхдэд үзлэг хийж, 11 хүүхдэд мэс засал эмчилгээ хийх заалтыг гаргалаа. Зочин профессорууд ажиллах хугацаандаа мэдрэл, зүрхний мэс заслын эмч нарыг хамруулсан 150 гаруй эмч нарт цахим, танхим хосолсон сургалтыг зохион байгууллаа.

Мөн Японы Токио хотын Хүүхдийн эрүүл мэндийн төвийн хүүхдийн тархи, нугасны мэдрэлийн мэс заслын зочин профессорын баг 9 дүгээр сард ирж ажиллаж, тархины саа, саажилт, хөдөлгөөний эмгэгтэй нийт 50 хүүхдэд хамтарсан багаар нарийвчилсан үзлэг оношилгоо хийн, зөвлөгөө өгч, үүнээс яаралтай мэс засал эмчилгээ шаардлагатай 6 хүүхдэд булчингийн чангарлыг тавиулж, хөдөлгөөний алдагдлыг засах нурууны мэдрэлийн арын ёзоор таслах ризотомид мэс засал эмчилгээг үнэ төлбөргүй хийлээ. Улсын гуравдугаар эмнэлэг нь Эрүүл мэндийн сайдаас 2023 онд тусгайлан үүрэг болгосон арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд хүүхдийн тархины сааны шалтгаант булчин чангарлын үеийн нугасны мэдрэлийн арын ёзоорыг сонгомлоор таслах ризотомид мэс заслын эмчилгээг өөрийн эх оронд бүрэн нутагшуулахаар ажиллаж байна. Цаашид мэс засал хийхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн зардал болон 2023 оноос ЭМДҮЗ-ийн тогтоолд мэс заслын өртгийг тусган 0-18 настай хүүхдэд үнэ төлбөргүй үзүүлэхээр төлөвлөж байна.

Тархины саажилт, уналт, таталтын эсрэг эмийн хангамжийн тасралтгүй байдлыг хангах хүрээнд тусламж, үйлчилгээнд хэрэглэж байгаа олон улсын нэршлээр 53 нэрийн эмийг тодорхой шалгуураар үнэлж, Монгол Улсад эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, нэн шаардлагатай, 0-18 насны хүүхдэд хэрэглэх уналт таталтын эсрэг 10 нэрийн эмийг хоёр жилийн хугацаатайгаар өнчин эмийн бүртгэлд бүртгэж, 21 эмэнд импортын нэг удаагийн лиценз олгож байна. Монгол Улсад бүртгэлтэй болон нэг удаагийн импортын лицензээр импортолсон нийт олон улсын нэршлээр 53, худалдааны нэршлээр 93 нэрийн уналт таталтын эсрэг эмийн нөөцийн нэгтгэлийг нэг өдрийн дундаж хэрэглээнд харьцуулан тооцоолоход 30-аас дээш хоногийн нөөцтэй 16 нэрийн эм байгаа бол 30-аас цөөн хоногийн нөөцтэй 7 нэр төрлийн эм байна. Үүний худалдан авалт, нөөцийн тасалдалгүй байдлыг хангахад онцгой анхаарч байна.

Эрүүл мэндийн яамнаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эмчилгээнд хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийн чиглэлээр гол баримталж байгаа бодлогын хувьд эм бүртгэлийн үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, эмийн худалдааны үнэнд тухай бүрд хяналт хийх, эмийн хэрэгцээг тооцоолон олон нийтийг үнэн зөв мэдээллээр хангах, нэн шаардлагатай, цөөн тоогоор хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн асуудлыг шийдвэрлэх асуудалд онцгой анхаарч байна.

Дөрөв. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд саад бэрхшээлгүй оролцох, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн холбогдох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал:

Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр 2017-2024 онд хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд мэдээллийн хүртээмжийг сайжруулах зорилгоор харааны бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн “Монгол хэлний бичвэрийг ярианд хөрвүүлэх” программ хангамжийг хөгжүүлж, туршилтын ажлыг эхлүүлээд байна. Энэхүү программ нэвтэрснээр цахим үйлчилгээ, нийтийн тээвэр, ресторан, зоогийн газар, банк зэрэг бусад үйлчилгээний байгууллагад бүрэн ашиглаж, харааны бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээний хүртээмж сайжирч нийгмийн харилцаанд тэгш оролцох боломж бүрдэх юм.

ЖАЙКА байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх төсөл”-ийн

хүрээнд Монгол Улсад анх удаа төр, төрийн бус байгууллага хамтран мэдээллийн хүртээмжийг үнэлгээг хийж, холбогдох байгууллагуудад зөвлөмж боловсруулан хүргүүлсэн. Харааны бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн хүртээмжийг 9, сонсголгүй иргэдийн мэдээллийн хүртээмжийг 7 шалгуур үзүүлэлтээр үнэлж тодорхой дүгнэлт, зөвлөмжийг өгсөн. Дүгнэлтэд үндэслэн олон нийтийн телевизэд дохионы орчуулга болон үсгэн тайлбар оруулах олон улсын стандарт H.702-г нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангаж, веб сайтын болон IP телевизийн хүртээмжийг хангах олон улсын зөвлөмж /WCAG2.0/-ийг Харилцаа, холбооны зохицуулах холбооноос баталсан.

Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар барилга, байгууламжийн норм, нормативын баримт бичиг "Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх" /БНБД 31-23-22/-ийг баталж, мөрдөн ажиллаж байна. Мөн Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар "Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-ийг шинэчлэн боловсруулахаар ажиллаж байна.

Барилга, хот байгуулалтын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар "Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг төрөөс орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөр"-ийг баталсан. Энэхүү хөтөлбөр хэрэгжсэнээр түрээсийн орон сууцанд хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн хамрагдах хувь хэмжээг нэмэгдүүлэх, орон нутгийн өмчийн орон сууцнаас тэргүүн ээлжид орон байргүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхийг хөлслүүлэх, эзэмшүүлэх, төлбөрийн уян хатан, хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдан авах боломж бүрдэх юм.

Зам, тээврийн хөгжлийн яамнаас "Явган хүний зам, талбайн төсөвлөлт болон техникийн шаардлага"-ыг 2020 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоотойгоор боловсруулж батлуулахдаа "зам, замын байгууламжид үнэлгээ хийх "Шалгах хуудас"-ыг тусгаж, дэд бүтцийн хүртээмжийн үнэлгээ хийх албан ёсны баримт бичигтэй болсон.

"Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа Ерөнхий шаардлага MNS 5633:2019" стандартын Норматив эшлэлд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцыг нэмж тусган шинэчлэн боловсруулж, 2023 онд Хүүхдийн хөгжил, хамгааллын стандартчиллын техникийн хороогоор хэлэлцэн баталсан.

2022 онд Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн зам, замын байгууламж, нийтийн тээврийн үйлчилгээний саадгүй байдал, хүртээмж, Төрийн ордон, бүх яам, нийслэлийн ЗДТГ, төвийн 6 дүүргийн ЗДТГ (нийт 24 байгууллага)-ын барилга байгууламж болон мэдээллийн технологи, харилцаа холбооны үйлчилгээний саадгүй байдал, хүртээмжид 3 чиглэлээр үнэлгээ хийж, талуудад зөвлөмж хүргүүлсэн.

Саадгүй байдал, хүртээмжийн үнэлгээг барилга байгууламж, авто зам, замын байгууламж, нийтийн тээвэр болон мэдээллийн технологи, харилцаа холбооны чиглэлээр үнэлгээ хийж, зөвлөмжийн дагуу засаж сайжруулах арга хэмжээ авснаар үнэлгээ хийсэн газар, нутагт Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж улмаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр, эрхлэлтийг дэмжиж, нийгмийн харилцаанд саадгүй оролцох боломж нөхцөл нэмэгдэнэ гэж үзэж байна.

Төрийн үйлчилгээг хүртээмжтэй болгох зорилгоор E-Mongolia, ndaatgal, E-halamj, E-Job цахим системийг нэвтрүүлж, сонсголгүй иргэдэд төрийн үйлчилгээг саадгүй хүргэх зорилгоор Зайнаас туслан зөвлөх төвийг байгуулан ажиллуулж байна.

Мэдээллийн хүртээмжийг сайжруулах хүрээнд Ковид-19 цар тахлын үед 2020 онд теле хичээл, төрийн байгууллагаас цар тахлын тухай мэдээлэл, зөвлөмж болон УИХ-ын сонгуулийн сурталчилгаа, сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг зэрэг нь дохионы хэлтэй гарч байсан учраас хүртээмжтэй телевизийн тоо, нэвтрүүлгийн хувь өмнөх жилүүдээс өндөр гарсан байна. Харин 2022 онд нийт 35 телевизээр мэдээ, мэдээлэл, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн бол 2023 оны байдлаар нийт 42 телевизээр нийт хөтөлбөрийн 3.79 хувь нь дохионы хэлтэй, харин 16 телевизийн хөтөлбөрүүдийн 1.2 хувь нь хадмал тайлбартай байсан. Тухайлбал, Монголын үндэсний олон нийтийн телевиз, ТВ8, С1, Парламент, Сүлд, ТВ9, Монгол HD ТВ, ЕТВ, MNC, SBN, NTV зэрэг телевиз өдөр тутмын мэдээ, мэдээллийн хөтөлбөр, С1 телевиз Парламентын мэтгэлцээний тэмцээнийг, Монгол телевиз “Өнөө өглөө” хөтөлбөрийн амралтын өдрийн дугаараа, Like, NTN телевизүүд “Эрүүл мэндийн зөвлөгөө” нэвтрүүлгээ, Малчин телевиз “Цаг агаарын хөтөлбөр” зэргийг дохионы хэлмэрчтэйгээр нэвтрүүлж байна. Түүнчлэн Засгийн газрын хуралдааны мэдээлэл, төрийн байгууллагууд нэвтрүүлгүүдээ дохионы хэлтэйгээр тогтмол бэлтгэн хүргэж байна. Central, TenGer, Star, C channel, Авто телевизүүд мэдээллийн хөтөлбөр, танин мэдэхүйн нэвтрүүлэг зэргийг, Монгол телевиз зарим хүүхэлдэйн киног хадмал тайлбартайгаар нэвтрүүлж байна. Түүнчлэн Улсын их баяр наадмын нээлтийг дохионы орчуулгатайгаар олон нийтэд хүргэдэг болсон. Цаашид мэдээллийн хүртээмжийг сайжруулах чиглэлээр онцгой анхаарч ажиллах болно.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд “Монгол дохионы хэлний хэлмэрч бэлтгэх сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулан дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийг Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төв дээр мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагыг түшиглэн бэлтгэж эхлээд байна.

Бүрэн хараагүй болон харааны бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд бусад хүмүүсийн нэгэн адил тэгш оролцох, бусад хүмүүс харааны бэрхшээлтэй иргэдтэй брайл үсгээр дамжуулан харилцах, бие биедээ туслах, харилцан суралцах боломжийг бүрдүүлэх, мэдээллийн хүртээмжийг сайжруулахад чиглэсэн “Монгол брайл бичгийн MNS6800:2019” стандартыг батлан хэрэгжүүлж байна.

Тав. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн талаар

Хөдөлмөрийн насны 90.0 орчим мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэний 13.0 мянга гаруй нь хөдөлмөр эрхэлж байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн ажлын байрны төлбөрийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулахтай холбоотой өөрчлөлт орсон. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрхтэй холбоотой шинэлэг зохицуулалтууд тусгагдсан.

2021 онд хийсэн судалгаагаар улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нийгмийн даатгалын санд бүртгэлтэй 25-аас дээш ажилтантай 6511 байгууллага

байгаагаас 3242 аж ахуйн нэгж, байгууллага буюу 50 гаруй хувьд нь Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийн хяналт, үнэлгээ хийхэд 9600 орчим хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулахаас 7200 гаруй иргэн ажиллаж байгаа буюу хуулийн хэрэгжилт аж ахуйн нэгж, байгууллагад 61 хувь, төрийн байгууллагад 59 хувийн хэрэгжилттэй байгаа дүгнэлт гарсан.

Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь аж ахуйн нэгж, байгууллагын хууль эрх зүйн талаарх ойлголт, хуулийн хэрэгжилтэд тавих хяналт сул байгаатай холбоотой юм. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хөдөлмөрийн хяналтын чиг үүрэг шилжсэн нь өмчийн хэлбэр харгалзахгүй бүх байгууллагуудад хяналт шалгалт хийж, хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх боломж бүрдсэн гэж үзэж байна. Түүнчлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийг нэмэгдүүлэх боломжтой болно.

Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйл (өмнө хүчин төгөлдөр байсан хуулийн 111 дүгээр зүйл)-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүйн ажлын байрны төлбөрөөс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 2016 онд 349.5 сая, 2017 онд 1.0 тэрбум, 2018 онд 1.1 тэрбум, 2019 онд 3.6 тэрбум, 2020 онд 8.0 тэрбум, 2021 онд 11.5 тэрбум, 2022 онд 4.7 тэрбум, 2023 оны эхний 3 дугаар улирлын байдлаар 2.8 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг дараа оны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөвт хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зориулалтаар тусгадаг бөгөөд өмнөх оны орлогоос илүү хэмжээний хөрөнгийг тухайн жил бүр тусган холбогдох үйл ажиллагаанд зарцуулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийн хувьд 2016 онд 2.3 тэрбум төгрөг зарцуулж 2186 ажлын байр, 2017 онд 3.1 тэрбум төгрөг зарцуулж 1461 ажлын байр, 2018 онд 3.6 тэрбум төгрөг зарцуулж 1376 ажлын байр, 2019 онд 3.5 тэрбум төгрөг зарцуулж 1161 ажлын байр бий болсон. 2020 онд 2,844 иргэн хамрагдаж 3.3 тэрбум төгрөг зарцуулж 1089 ажлын байр, 2021 онд 6.4 тэрбум төгрөг зарцуулж 1265 ажлын байр, 2022 онд 9.5 тэрбум төгрөг зарцуулж 1225 ажлын байр тус тус бий болгосон. Харин 2023 оны эхний 3 дугаар улирлын байдлаар тус хөтөлбөр, арга хэмжээнд 7.5 тэрбум төгрөг зарцуулж 2479 иргэнийг хамруулан 886 ажлын байрыг бий болгоод байна.

Япон Улсын буцалтгүй тусламжаар ЖАЙКА байгууллагатай хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийг 2021 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Энэ төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төлөвлөгөөг боловсруулж, хүний нөөцийг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажилладаг байгууллага хоорондын сүлжээтэй болох, ажлын байрны тохируулгат орчин нөхцөлийг бүрдүүлэх талаар аж ахуйн нэгж, байгууллагад зөвлөгөө өгдөг ажлын байранд дадлагажуулагчийн тогтолцоо бүрдэх юм.

Төслийн хүрээнд 2021 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар “Ажлын байрны дадлагажуулагч буюу Жоб көүч” ажил мэргэжлийг Үндэсний ажил мэргэжлийн ангилал тодорхойлолт жагсаалтад оруулж, “Ажлын байрны дадлагажуулагчийн үйл ажиллагааны удирдамж”-ийг батлуулан хэрэгжилтийг хангах зорилгоор “Загвар төсөл”-ийг хэрэгжүүлж байна.

Зургаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх талаар

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ MNS 6752:2019 стандартыг батлуулж, хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүнд тэгш, хүртээмжтэй үзүүлэхэд байгууллагад тавигдах нийтлэг шаардлагыг тогтоож өгсөн.

Мөн нийслэлийн Чингэлтэй дүүргийн 149 дүгээр сургуультай хамтран багш, ажилчид, эцэг эхчүүдийн хүүхдийн эрх хамгаалал, хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт хандлагыг дээшлүүлж, зөвлөгөө өгөх, хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний чанарыг сайжруулах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах, хөгжүүлэх үйл ажиллагааны “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй сургууль”-ийн загвар төслийг хэрэгжүүлсэн.

Хүүхдийн хөгжлийн цогц үйлчилгээний төвүүдийг байгуулж, санхүүжилтийг төрөөс олгуулах саналын дагуу Хүүхэд хамгааллын тухай хууль болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2018-2023 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн үүсгэн байгуулсан 20 гаруй ТББ-уудтай 700.0 гаруй сая төгрөгийн гэрээ байгуулан хамтран ажилласан байна. Цаашид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэгийн үйлчилгээ үзүүлэхэд салбар дундын уялдаа холбоог хангаж санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхэд бүх талаар анхаарч ажиллах болно.

Долоо. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн хамгааллын үйлчилгээний талаар

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, хагас, бүтэн өнчин хүүхэд, өрх толгойлсон эх, эцэг болон нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэдэд төрөөс нийт 72 нэр төрлийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийн үйлчилгээг хүргэж байна.

Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэн, ахмад настныг асарч байгаа иргэнд олгох тэтгэмжийн хэмжээ 2018 онд 84000 төгрөг байсныг 123100 төгрөг, 2023 оны 7 дугаар сарын 1-ээс 275000 төгрөг болгон тус тус нэмэгдүүлэн 8 дугаар сарын байдлаар 14400 гаруй иргэнд 13.2 тэрбум төгрөг олгосон байна. Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа 12700 орчим иргэнд 15.1 тэрбум төгрөг олгожээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгож байсан 188000 төгрөгийн тэтгэврийн хэмжээг цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан 2020 онд 288000 төгрөг болгон нэмэгдүүлсэн ба 2023 оны 7 дугаар сараас эхлэн 325000 төгрөг болгон нэмэгдүүлж, мөн оны 8 дугаар сарын байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 36400 гаруй иргэнд 76.3 тэрбум төгрөг олгоод байна.

Засгийн газрын 2021 оны 363 дугаар тогтоолоор нийгмийн халамжийн сангаас 65 нэр төрлийн протез, ортопед, тусгай хэрэгслийн үнийг 20-50 хувиар нэмэгдүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хүрээнд 2020-2022 онд протез, ортопед, тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтийг 36000 орчим хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгож, 8.6 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Нийгмийн даатгалын багц хуулийн хүрээнд Тэтгэврийн даатгалын сангаас 2022 оны жилийн эцсийн байдлаар 62.2 мянган хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид 316.7 тэрбум, 2023 оны 8 дугаар сарын байдлаар 63.1 мянган тэтгэвэр авагчид 220.1 тэрбум төгрөгийн тэтгэврийг тус тус олгосон байна.

Мөн Тэтгэмжийн даатгалын сангаас 2022 оны жилийн эцсийн байдлаар 162.3 мянган хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авагчид 27.4 тэрбум, 2023 оны 8 дугаар сарын байдлаар 93.5 мянган хүнд 19.1 тэрбум төгрөгийн тэтгэмж тус тус олгосон.

Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 2022 онд 3.6 мянган хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид 27.5 тэрбум, мөн сангаас 1.2 мянган даатгуулагчид 1.3 тэрбум төгрөгийн тэтгэмж төлбөр, 2.0 мянга гаруй даатгуулагчид 1.1 тэрбум төгрөгийн сувиллын зардлыг тус тус олгосон бол 2023 онд 3.5 мянган хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид 19.7 тэрбум төгрөгийг, мөн тус сангаас 1.0 мянган даатгуулагчид 1.1 тэрбум төгрөгийн тэтгэмж, төлбөр, 1.1 мянга гаруй даатгуулагчид 0.7 тэрбум төгрөгийн сувиллын зардлыг тус тус олгосон байна.

Дүгнэж хэлбэл манай улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүр нийгмийн даатгалын болон халамжийн сангаас тэтгэвэр авч байгаа бөгөөд цаашид нийгмийн халамжийн үйлчилгээний нэр төрлийг оновчтой болгон багцалж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох мөнгөн дүнг нэмэгдүүлэх нь зүйтэй.

Найм. Хөгжлийн бэрхшээлтэй хүний бусад эрхийн талаар

Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах эрхийг хангах хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батлан хэрэгжүүлж байна.

Түүнчлэн 2017-2020 оны хооронд олон улсын тэмцээн, уралдаанд оролцон амжилт үзүүлсэн ч урамшууллаа авч чадахгүй байсан 43 тамирчинд олгох 268 гаруй сая төгрөгийг олгохтой холбоотой асуудлыг Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, ХХҮЕГ-аас тамирчдын мөнгөн урамшууллыг олгох ажлыг зохион байгуулсан. Цаашид хөгжлийн бэрхшээлтэй тамирчдын урамшууллын асуудлыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон Засгийн газрын 2018 оны “Журам шинэчлэн батлах тухай” 173 дугаар тогтоолд өөрчлөлт оруулж, тус зардлыг бүхэлд нь биеийн тамир, спортыг дэмжих сангаас олгох зохицуулалтыг тусгахаар төлөвлөж байна.

Биеийн тамир, спортын улсын хороо, Монголын тусгай олимпын хороо, Паралимпын хороо, Дифлимпын хороо гэсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир, спортоор хичээллүүлэх, олон улсын уралдаан тэмцээнд оролцуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-тай 2021-2023 онд хамтран ажиллах Санамж бичиг байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг биеийн тамир спортоор хичээллүүлж, хөгжүүлэх, олон улс, тив, дэлхийн хэмжээний уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэх, тамирчдын гаргасан амжилт олон нийтэд түгээх, алдаршуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд олон улсын уралдаан тэмцээнд оролцох зардлыг “Хүүхдийн төлөө сан”-аас гаргах зохицуулалтыг бий болгосон.

Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн хандлага ойлголтыг нэмэгдүүлэх, хүртээмжтэй орчныг бүрдүүлэх замаар тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, бие даан амьдрах боломжийг бүрдүүлэхэд анхаарч ажиллаж байна.

Ес. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, нийгмийн бүхий л харилцаанд ямар нэг алагчлалгүйгээр оролцуулах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд ойрын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс 5 жилийн дараа хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэхэд хуулийн давхардал 24.4 хувь, зөрчил 35.5 хувь, хийдэл 13.3 хувийг тус тус эзэлж байна. Нийт давхардлын 61 хувь нь нийгмийн халамж, 34 хувь нь боловсрол, 5 хувь нь бусад харилцаатай холбоотой байна. Иймд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд тэдний үндсэн эрхийг баталгаажуулж, хамгаалах, хариуцах этгээдийн чиг үүргийг нарийвчлан тодорхойлох зэрэг процедурыг бусад салбар хуулиар зохицуулах байдлаар тус хуульд шинэчилсэн найруулга хийх шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан.

Тиймээс тус хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байгаа бөгөөд нэр томъёог Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцод нийцүүлэх, хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголт нэмэгдүүлэх сургалтыг тогтолцоог тодорхой болгох, бие даан амьдрах эрхийг хэрэгжүүлэх үүднээс “Дэмжих үйлчилгээ”-г илүү тодорхой болгож, ажлын байрны дадлагажуулагчийн тогтолцоог бүрдүүлэх зэрэг асуудлыг шинээр тусгасан. Хуулийн төсөл боловсруулах явцад төр болон төрийн бус байгууллагын төлөөлөлд 9 удаа хэлэлцүүлэн санал авсан бөгөөд ирсэн саналуудыг тусган Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр яамдаас санал авахад бэлтгэн ажиллаж байна.

Түүнчлэн “Саадгүй байдал, хүртээмжийн тухай” анхдагч хуулийн төслийг боловсруулан, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Тус хуулиар нийтийн тээврийн хүртээмж, барилга байгууламж, авто зам, замын байгууламжийн хүртээмж, мэдээлэл, харилцаа холбооны хүртээмж, үйлчилгээний хүртээмжийн асуудлыг зохицуулна. Хууль батлагдсанаар орон сууц, олон нийтийн барилга байгууламж, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологийн болон үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, олон улсын түгээмэл загварт нийцүүлэн, иргэд нийгмийн харилцаанд оролцоход дэд бүтэц, мэдээлэл, үйлчилгээний хүрээнд тохиолдож буй саад бэрхшээлүүдийг арилгаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд оролцох, сурч боловсрох, хөдөлмөр эрхлэх боломж нэмэгдэх юм. Хуулийн төслийг төрийн болон төрийн бус байгууллагуудад 8 удаа хэлэлцүүлж тэдний саналыг тусгасан.

Мөн Нийгмийн халамжийн багц хуулийн шинэчлэлийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамжийн тэтгэврийг цаашид амьжиргааны баталгаажих түвшин, инфляцтай уялдуулан нэмэгдүүлэх бодлого баримтална.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, хөтөлбөр төслийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хөгжлийн бэрхшээлтэй хүний

хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг нарийвчлан тусгаж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан олон нийтэд танилцуулан хэлэлцүүлж, иргэд олон нийтээс санал авах арга хэмжээг 2022-2023 оны хооронд өргөн хүрээгээр зохион байгуулж, олон нийт, төр, төрийн бус байгууллагын төлөөлөл, хуулиар эрх ашиг нь хөндөгдөх хэсэг, өрх толгойлсон эцэг, эхчүүдэд нийт 9 удаагийн томоохон хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хуулийн төсөлд хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүний эрх ашгийг тэргүүн ээлжид анхаарахад чиглэсэн тусгайлсан зохицуулалтуудыг тусгасан.

Түүнчлэн Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журмын дагуу сонгон шалгаруулалтад орж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад тавигдах шаардлагад хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн харилцаанд саад бэрхшээлгүй оролцоход чиглэсэн стандартуудыг заавал дагаж мөрдсөн байх, Хөдөлмөрийн тухай хуулийн 25 ба түүнээс дээш ажилтантай байгууллага нийт ажилтны дөрвөөс доошгүй хувьд хөгжлийн бэрхшээлтэй ажилтан ажиллуулах заалтыг заавал хэрэгжүүлсэн байх тухай зохицуулалт нэмж тусган батлуулна.

Ирэх онд нийслэлд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, хөгжлийн нэгдсэн төв, Архангай, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь аймгуудад болон Баянзүрх дүүрэгт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг, цаашид төвийг бүх аймаг, дүүрэгт барьж байгуулна.

“Ховор тохиолддог өвчин, эмгэгийг эмчлэх болон гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэн үед шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, эмнэлгийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгслийн худалдан авалт, ханган нийлүүлэлт, нөөц бэлэн байдлын асуудал хариуцсан байгууллагыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд байгуулах” талаар Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, төв байгуулах асуудлыг судлан, бэлтгэл ажлыг хангаж байна.

ЭХЭМҮТ-д Ураг нярайн үеийн илрүүлэг, шинжилгээний талаар сүүлийн 10 жилийн судалгаа хийсэн. Үр дүнд нийт амьд төрөлтийн 0.5-1 хувьд нь хромосомын эмгэг илэрсэн байна. Илэрсэн өвчнүүдэд Дауны хам шинж 46 хувь, Эдвардсын хам шинж 21 хувь, бусад хам шинж 33 хувийг тус тус эзэлж байна. 35-аас доош насны эхийн урагт 30 хувьд нь хромосомын эмгэг оношлогдсон нь жирэмсэн эмэгтэйчүүдийг нас харгалзахгүй пренатал хавсарсан илрүүлэг шинжилгээнд хамруулах, эрсдэлийг тооцох шаардлага гарсан тул Пренатологийн төв байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

2023 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцдаг ерөнхий боловсролын 4 сургууль, 2 цэцэрлэгт нийт 800.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнийг улсын төсвөөр шийдвэрлэнэ.

Засгийн газраас Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангахад бүх шатанд салбар дундын уялдаа холбоог сайжруулж, тулгамдсан асуудал бүрийг шийдвэрлэхэд анхаарч ажиллах болно.